

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# СУРТАЛЧИЛГААНЫ ТАЙЛАН

*/5 сар/*



Чойр 2017 он

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРТАЛЧИЛГААНЫ ТАЙЛАН

2017-5-12


WEB [/govisumber@nso.mn/](http://govisumber@nso.mn/), Face book /Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтэс/ хаягаар хэлтсийн танилцуулга, инфографик зэрэг бүтээгдэхүүнүүдийг цаг тухайд нь байршуулан хэрэглэгчдэд сурталчилж байна. Аймгийн WEB хуудсанд холбогдсон учир [govisumber@gov.mn](http://govisumber@gov.mn) хаягаар мэдээлэлтэй танилцах боломжтой.

- Аймгийн “Хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлтийн төлөв байдал 2010-2016 он танилцуулга” гаргаж хэлтсийн вэб хуудсанд байршуулав.
- 2017 оны 4 дүгээр сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргаж аймгийн болон хэлтсийн вэб хуудсанд байршуулав.
- 2017 оны 5 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд Шивээговь, Баянтал сумдад зохион байгуулагдсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож Монгол улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлт 2016-1-11 сар, 2016 оны жилийн эцсийн байдлаар, аймгийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлт 2015, 2016 оны жилийн эцсийн байдлаар харьцуулсан үзүүлэлтээр, 2017 оны эхний 4 сарын нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлт, хүн амын амьжиргааны түвшний үзүүлэлтийг 2002-2016 оны үзүүлэлтээр брошур бэлтгэж бүтээгдэхүүнээ сурталчлав. Хэрэглэгчийн үнэлгээ санал асуулгыг 60 иргэнээс авдлаа.
- Аймгийн номын санд хэрэглэгчдэд зориулсан булангаа сэргээж 30 орчим ном, гарын авлага материал хандивлалаа.






Мэдээлэл тархаалтын ажлыг дараахь байдлаар хийлээ.

- “Говьсүмбэр аймгийн хүн ам, өрхийн үзүүлэлтийн үндсэн төлөв байдал 2010-2016 он” танилцуулга бэлтгэж цахимаар 100 гаруй хэрэглэгчид хүргүүлэв.
- 2016 оны 4 дүгээр сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргаж цахимаар 100 гаруй хэрэглэгчид хүргүүлэв.
- 2017 оны 5 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд Шивээговь, Баянтал сумдад зохион байгуулагдсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож давхардсан тоогоор 250 орчим иргэнд үйлчилгээ үзүүлснээс 120 гаруй иргэнд өөрийнх нь тухай сонирхолтой статистик мэдээлэл гарган өгч, 120 гаруй брошур тарааж, 30 орчим иргэнд Статистикийн мэдээ, танилцуулга гаргах, авах талаар заавар зөвлөгөө өгч ажиллалаа.
- Хэрэглэгчийн бүртгэлээр 26 үзүүлэлтийг 7 хэрэглэгчид тархаалаа. Тайлант хугацаанд 1 хэрэглэгч шинээр бүртгэгдсэн байна.





- Face book /Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтэс/, WEB хуудсанд /govisumbe.nso.mn/ , мөн аймгийн WEB хуудсанд /govisumber.gov.mn / танилцуулга болон бусад мэдээллийг тухай бүр нь байршуулан хэрэглэгчдэд түгээж байна.



Мэдээлэл бэлтгэсэн: Ахлах мэргэжилтэн

Я.Отгонбаяр